

Сурагчийн өөрийн үнэлгээ 1.

Даалгавар 1. Ангийн автобусаар явдаг сурагчдын нэг өглөөний автобус хүлээсэн минутын тоогоор өгөгдөл цуглуулжээ. Өгөгдлийн медианыг олж, зөв хариултыг сонгоорой.

15, 23, 7, 11, 5, 25, 12, 9, 5, 19, 18, 21, 6

A. 6.5 мин B. 12 мин C. 13.5 мин D. 20 мин /2 оноо/


Даалгавар 2. Ангийн автобусаар явдаг сурагчдын нэг өглөөний автобус хүлээсэн минутын тоогоор өгөгдөл цуглуулж, өсөх эрэмбээр байрлуулжээ.

Өгөгдлийн кватрил хоорондын далайцыг олж, зөв хариултыг сонгоорой.

5, 5, 6, 7, 9, 11, 12, 15, 18, 19, 21, 23, 25

A. 6.5 мин B. 12 мин C. 13.5 мин D. 20 мин /2 оноо/

Даалгавар 3. 60 сурагчийн сургууль төгсөх шалгалтад авсан оноог хуримтлагдсан давтамжийн графикаар харуулжээ. График ашиглан дараах үзүүлэлтүүдийг олж, нөхөөрэй.



- а. Медиан оноо $Q_2 =$
б. Доод кватрил $Q_1 =$
в. Дээд кватрил $Q_3 =$
г. Кватрил хоорондын далайцыг олоорой. $Q_3 - Q_1 =$

Линк:

https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSfJgKSF_AC3oe5XHyrnylrLA6wC4Inx2WvswonDzZ84jjLXww/viewform?usp=sharing